



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/33

Хэрлэн сум

Орон тооны бус зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", 29.3, Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолоор батлагдсан "Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах орон тооны бус захиргааны зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	-АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	-АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалт, өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн -Татварын хэлтсийн Татвар хураалтын тасгийн дарга -Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Хоёр. "Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга /Л.Бат-Октябрь/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/68 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 253